



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 10 сарын 25 өдөр

Дугаар 515

Улаанбаатар хот

Төрийн өмчид хөрөнгө хүлээн авах, хөрөнгө,
өр төлбөр бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1, 73.3 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Шүүхийн шийдвэрээр худалдан борлуулж, улсын төсөвт шилжүүлэхээр шийдвэрлэсэн боловч борлогдоогүй, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас санал болгосон, хавсралтад заасан 2 нэрийн, нийт 2,607,209,000.00 (хоёр тэрбум зургаан зуун долоон сая хоёр зуун есөн мянга) төгрөгийн үнэлгээ бүхий үл хөдлөх хөрөнгийг төрийн өмчид хүлээн авч, “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газарт эзэмшүүлж, үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Төрийн өмчид хүлээн авсан хөрөнгөтэй холбогдох 363,635,325.00 (гурван зуун жаран гурван сая зургаан зуун гучин таван мянга гурван зуун хорин тав) төгрөгийн өр төлбөрийг Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт төлж барагдуулахыг “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газар (Б.Гүрсоронзон)-т зөвшөөрсүгэй.

3.“Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Б.Гүрсоронзон, Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга Б.Түвшинтөгс нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1.Төрийн өмчид хүлээн авахаар шийдвэрлэсэн хавсралтад заасан хөрөнгийг хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

3.2.Хөрөнгө, өр төлбөрийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

3.3.Энэ шийдвэрийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлж, өмнөх өмчлөгчийн нэр дээрх өмчлөгчийн эрхийн гэрчилгээг хүчингүй болгуулах, төрийн өмчид бүртгэх ажлыг зохион байгуулж арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.Нарангэрэл

Д.НАРАНГЭРЭЛ

132002342
23-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 18 дугаар сарын 15-ны өдрийн
35 дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН ӨМЧИД ХҮЛЭЭН АВЧ, "АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН
ГАЗАРТ ЭЗЭМШҮҮЛЭХ, БҮРТГЭЛД ТУСГАХ ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Талбайн хэмжээ (м.кв)	Хөрөнгийн байршил	Улсын бүртгэлийн дугаар	Шинжээчийн тогтоосон үнэлгээ (төгрөг)
1	Үйлчилгээний зориулалттай үл хөдлөх хөрөнгө	292.53	Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 5 дугаар хороо, Тасганы овоо 23/1 дүгээр байрны 4 дүгээр давхар бүхэлдээ	Ү-2202027846	1,303,604,500.00
2	Үйлчилгээний зориулалттай үл хөдлөх хөрөнгө	292.53	Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 5 дугаар хороо, Тасганы овоо 23/1 дүгээр байрны 5 дугаар давхар бүхэлдээ	Ү-2202027847	1,303,604,500.00
	Нийт дүн				2,607,209,000.00 (хоёр тэрбум зургаан зуун долоон сая хоёр зуун есөн мянга)